Өлзийдундговь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
2018 оны ээлжит хурлын тэмдэглэл

2019 – 04 – 25

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Сайнцагаан сумын 7-р багт байрлах Өлзийдундговь ХК-ийн оффисст 2019 оны 04 сарын 25 ны өдрийн 17 цагт болов.

Хурлын дарга Н.Цоож хурлыг нээж, хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг мэдээлэв. Үүнд:

1. Н.Буянхүү 18126 ш
2. З.Эрдэнэбилэг /Х.Нарантуяа/ 70 ш
3. Б.Батаа /Түвшинжаргал/ 70 ш
4. С.Энхжаргал /Д.Өлзиймаа/ 348 ш
5. Д.Цэцэгдэлгэр/М.Энхбаяр/ 809ш
6. Н.Цоож 55702 ш
7. О.Алтангэрэл /А.Батбаяр/ 280 ш
8. С.Бат-Орших /С.Батжаргал/ 70 ш
9. Г.Эрдэнэбаатар 756 ш
10. Д.Мөнх-Очир 1470 ш
11. А.Батбаяр 70 ш
12. Б.Ганбаяр 102 ш
13. П.Аюусэд 70 ш
14. Ц.Энхтуяа 70 ш
15. Х.Нарантуяа 70 ш
16. Х.Төмөрсумъяа 350 ш

Бүгд 14 хүн хувьцааны тоо 78433 ш

Ирцийн хувь 82,13 %

Хуралд 78433 ш хувьцааг эзэмшигч 14 хүн хүрэлцэн ирж хурлын ирц 82,12 хувьтай байгааг мэдэгдэж хурлыг нээв.

Хурлын дарга Н.Цоож хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн даргаар хэнийг сонгох санал байгааг асуухад хувьцаа эзэмшигч Д.Мөнх-Очир хурлын нарийн бичгийн даргад П.Аюусэдийг санал болгов. Өөр саналтай хүн байгаа эсэхийг лавлахад байгаагүй тул хуралд оролцогчдын 100 хувийн саналаар П.Аюусэдийг хурлын нарийн бичгийн даргаар сонгов.

Хурлын дарга Н.Цоож хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

1.Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

3.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлаар хэлэлцэх асуудлаар өөр саналтай хувьцаа эзэмшигч байгаа эсэхийг асууж лавлахад өөр санал гараагүй учир хэлэлцэх асуудлыг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.

Хэлэлцэх асуудлын дагуу компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ТУЗ-ийн дарга Н.Буянхүү танилцуулав.